ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өвөрхангай аймгийн Богд сумын 1-р цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ӨВА-2022/4/НА-СТА-ТШЗ**


Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2022 он

Тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: batjargalo@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Гансүх

Утас: 70323833 Цахим хаяг: gansukh.audit@gmail.com

Аудитор: Б.Алтанцэцэг

Утас: 99016193 Цахим хаяг:altaa_6116@yahoo.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ..... 2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 11
3. Аудитын тайлан ..... 11
3.1 Ерөнхий зүйл ..... 11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ..... 12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 12
3.4 Материаллаг байдал ..... 13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ..... 13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ..... 14
3.8 Аудитын гол асуудал ..... 14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 14
4. Аудитын илрүүлэлт ..... 15
4.1 Залруулсан алдаа ..... 15
4.2 Төлбөрийн акт ..... 15
4.3 Албан шаардлага ..... 15
4.4 Зөвлөмж ..... 15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ..... 15

### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

БОГД СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Л.ДОЛГОРСҮРЭН ТАНАА

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас/Факс: (976) 7032 3253,
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2022.02.14 № 141
танай ____________-ны №____________-т

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 -д заасны дагуу Богд сумын Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Богд сумын Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

D:\Auditiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

# Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

төгрөгөөр

| Данс код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **33,860,306.14** | **46,084,521.00** |
| 33 | АВЛАГА | 537,168.14 | - |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 537,168.14 | |
| 33102 | НДШ-ийн авлага | 8,340.00 | |
| 33103 | ХАОАТ-ын авлага | 528,828.00 | |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **33,323,138.00** | **46,084,521.00** |
| 35400 | Хангамжийн материал | 33,323,138.00 | 46,084,521.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,353,500.00 | 1,353,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 27,925,692.00 | 29,322,486.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | | |
| 35460 | Хүнсний материал | 4,043,946.00 | 15,408,535.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **393,948,769.65** | **376,211,746.33** |
| **371** | **Урт хугацаат хадгаламж** | - | - |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **393,948,769.65** | **376,211,746.33** |
| 39200 | Биет хөрөнгө | 385,700,769.65 | 367,963,746.33 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 372,563,357.81 | 372,563,357.81 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл - Барилга | (25,081,079.52) | (37,979,029.32) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | | |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 36,946,870.00 | 40,286,074.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл - Тоноглол төхөөрөмж | (19,551,700.56) | (24,199,537.40) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 12,690,619.70 | 12,690,619.70 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл -Тавилга | (5,699,697.02) | (6,925,937.54) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 23,042,000.00 | 23,042,000.00 |
| 39215 | Бусад үндсэн хөрөнгө элэгдэл | (9,448,500.76) | (11,752,700.92) |
| 39217 | Номын фонд | 238,900.00 | 238,900.00 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 8,248,000.00 | 8,248,000.00 |
| 39301 | Програм хангамж | 245,000.00 | 245,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (245,000.00) | (245,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 8,248,000.00 | 8,248,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | | |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **427,809,075.79** | **422,296,267.33** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | 0.00 | 218,800.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | | 218,800.00 |
| 411 | Богино хугацаат үнэт цаас | 0.00 | - |
| 413 | Өглөг | | 218,800.00 |
| 4136 | Бусад өглөг | | 218,800.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | | |
| 41363 | Татварын өглөг /ТӨҮГ/ | | |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **427,809,075.79** | **422,077,467.33** |

| | | | |
|---|---|---|---|
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 427,809,075.79 | 422,077,467.33 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 162,593,306.00 | 162,593,306.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 20,130,463.47 | 14,398,855.01 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 20,130,463.47 | 20,130,463.47 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | (5,731,608.46) |
| 51230 | Давхардсан гүйлгээ цэвэрлэх данс | | |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 245,085,306.32 | 245,085,306.32 |
| 51400 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **427,809,075.79** | **422,296,267.33** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **270,023,910.00** | **256,264,022.00** |
| 110 | Орлогын албан татвар | - | - |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **19,480,000.00** | **4,551,394.00** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 19,480,000.00 | 4,551,394.00 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 19,480,000.00 | 4,551,394.00 |
| 1200042 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 19,480,000.00 | 1,212,190.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | | 3,339,204.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **250,543,910.00** | **251,712,628.00** |
| **1310** | **Улсын төсвөөс** | **216,792,210.00** | **216,910,500.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 216,792,210.00 | 216,910,500.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | **33,751,700.00** | **34,802,128.00** |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 31,811,700.00 | 34,126,500.00 |
| 133004 | Дээд шатны төсвийн эрх захирагчаас олгосон санхүүжилт | 1,940,000.00 | 675,628.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **269,141,114.55** | **261,995,630.46** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **269,141,114.55** | **261,995,630.46** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **258,461,649.55** | **258,479,466.40** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 162,589,372.00 | 151,822,950.00 |
| 210101 | Үндсэн цалин | 109,620,234.00 | 95,742,962.00 |
| 210102 | Нэмэгдэл | 37,503,762.00 | 46,214,420.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210104 | Урамшуулал | 15,465,376.00 | 9,865,568.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 19,716,800.86 | 21,836,444.23 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 13,026,200.86 | 15,837,054.20 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,672,700.00 | 1,512,944.60 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,338,100.00 | 1,210,256.02 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 508,892.50 | 297,844.17 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,170,907.50 | 2,978,345.24 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 27,631,465.00 | 30,157,437.85 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,613,410.00 | 2,146,735.35 |
| 210302 | Түлш, халаалт | 18,406,080.00 | 20,398,702.50 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,611,975.00 | 7,612,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 5,526,716.00 | 10,700,796.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 514,300.00 | 1,198,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,472,516.00 | 1,575,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 935,400.00 | 2,015,400.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 240,000.00 | 100,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,364,500.00 | 2,755,500.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | | 3,055,996.00 |
| 2105 | Норматив зардал | 18,130,324.00 | 22,306,011.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 264,600.00 | |
| 210502 | Хоол, хүнс | 17,865,724.00 | 22,306,011.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | - | 166,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | | 166,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 265,000.00 | 224,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 132,000.00 | 224,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 133,000.00 | |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 24,601,911.69 | 21,265,327.32 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 205,000.00 | 189,100.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 24,396,911.69 | 21,076,227.32 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **10,679,465.00** | **3,516,164.06** |

| | | | |
|---|---|---|---|
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **350,000.00** | **210,900.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшуулал | | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 350,000.00 | 210,900.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **10,329,465.00** | **3,305,264.06** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 10,329,465.00 | 3,305,264.06 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **882,795.45** | **(5,731,608.46)** |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | - | - |
| 5 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 734,354,858.45 | - |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ | 734,354,858.45 | |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 734,354,858.45 | |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | | |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | (733,472,063.00) | (5,731,608.46) |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**Төгрөгөөр**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 162,593,306.00 | 245,085,306.32 | 20,130,463.47 | 427,809,075.79 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | 0.00 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 162,593,306.00 | 245,085,306.32 | 20,130,463.47 | 427,809,075.79 |
| C08 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 162,593,306.00 | 245,085,306.32 | 20,130,463.47 | 427,809,075.79 |
| D01 | 2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 162,593,306.00 | 245,085,306.32 | 20,130,463.47 | 427,809,075.79 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 162,593,306.00 | 245,085,306.32 | 20,130,463.47 | 427,809,075.79 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | (5,731,608.46) | (5,731,608.46) |
| D09 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 162,593,306.00 | 245,085,306.32 | 14,398,855.01 | 422,077,467.33 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **250,543,910.00** | **251,712,628.00** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | - | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **250,543,910.00** | **251,712,628.00** |
| 1310 | Улсын төсвөөс | 216,792,210.00 | 216,910,500.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 216,792,210.00 | 216,910,500.00 |
| 1330 | Төсвийн захирагчдаас | 33,751,700.00 | 34,802,128.00 |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 31,811,700.00 | 34,126,500.00 |
| 133004 | Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт | 1,940,000.00 | 675,628.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **248,603,910.00** | **251,712,631.00** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 248,603,910.00 | 251,712,631.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 237,924,445.00 | 248,196,466.94 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 163,118,200.00 | 151,294,122.00 |
| 210101 | Үндсэн цалин | 110,149,062.00 | 95,214,134.00 |
| 210102 | Нэмэгдэл | 37,503,762.00 | 46,214,420.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | |
| 210104 | Урамшуулал | 15,465,376.00 | 9,865,568.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 19,715,600.00 | 21,828,107.09 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 13,025,000.00 | 15,828,714.06 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,672,700.00 | 1,512,944.60 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,338,100.00 | 1,210,256.02 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 508,892.50 | 297,844.17 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,170,907.50 | 2,978,345.24 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 27,631,465.00 | 30,157,437.85 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,613,410.00 | 2,146,735.35 |
| 210302 | Түлш, халаалт | 18,406,080.00 | 20,398,702.50 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,611,975.00 | 7,612,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 6,597,780.00 | 5,942,200.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 449,800.00 | 234,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | |

| | | | |
|---|---|---|---|
| | | 2,699,980.00 | 1,575,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,075,400.00 | 2,015,400.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 200,000.00 | 164,100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 240,000.00 | 200,900.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,932,600.00 | 1,752,400.00 |
| 2105 | Нормативт зардал | 16,901,000.00 | 34,138,600.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,032,600.00 | 67,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 15,366,200.00 | 33,670,600.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 502,200.00 | 401,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,497,200.00 | 3,365,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,497,200.00 | 3,365,500.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | - | 166,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | | 166,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 752,300.00 | 274,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 619,300.00 | 274,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 133,000.00 | |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,710,900.00 | 1,030,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 210,900.00 | 210,900.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,500,000.00 | 819,100.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 10,679,465.00 | 3,516,164.06 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 11,029,465.00 | 3,727,064.06 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас санхүүжилт | 10,329,465.00 | 3,305,264.06 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 10,329,465.00 | 3,305,264.06 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 350,000.00 | 210,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 350,000.00 | 210,900.00 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | 1,940,000.00 | - |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 1,940,000.00 | - |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 1,940,000.00 | - |
| 223 | Бусад хөрөнгө | 1,940,000.00 | |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | (1,940,000.00) | - |

| | | | |
|---|---|---|---|
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **273,678,500.00** | **238,274,445.00** | **255,436,900.00** | **251,037,000.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **273,678,500.00** | **238,274,445.00** | **255,436,900.00** | **251,037,000.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **273,328,500.00** | **237,924,445.00** | **255,226,000.00** | **247,705,463.94** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **163,118,200.00** | **162,589,372.00** | **151,302,300.00** | **151,294,122.00** |
| 210101 | Үндсэн цалин | 105,481,400.00 | 109,152,810.00 | 105,654,900.00 | 95,214,134.00 |
| 210102 | Нэмэгдэл | 43,604,400.00 | 38,500,014.00 | 35,940,500.00 | 46,214,420.00 |
| 210104 | Урамшуулал | 14,032,400.00 | 15,465,376.00 | 9,706,900.00 | 9,865,568.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **19,715,600.00** | **19,715,600.00** | **22,922,700.00** | **21,828,104.09** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 13,025,000.00 | 13,025,000.00 | 16,782,700.00 | 15,828,714.06 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,672,700.00 | 1,672,700.00 | 1,535,000.00 | 1,512,944.60 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,338,100.00 | 1,338,100.00 | 1,228,000.00 | 1,210,256.02 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 334,500.00 | 417,372.23 | 307,000.00 | 297,844.17 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,345,300.00 | 3,262,427.77 | 3,070,000.00 | 2,978,345.24 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **30314500.00** | **27631465.00** | **30,761,000.00** | **30,157,437.85** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,000,000.00 | 1,613,410.00 | 2,442,200.00 | 2,146,735.35 |
| 210302 | Түлш, халаалт | 19,702,500.00 | 18,406,080.00 | 20,706,800.00 | 20,398,702.50 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,612,000.00 | 7,611,975.00 | 7,612,000.00 | 7,612,000.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | **7,722,400.00** | **6,597,780.00** | **5,560,800.00** | **5,451,200.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 449,800.00 | 449,800.00 | 234,400.00 | 234,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,700,000.00 | 2,699,980.00 | 1,500,000.00 | 1,575,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,200,000.00 | 1,075,400.00 | 2,200,000.00 | 2,015,400.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 200,000.00 | 200,000.00 | 164,100.00 | 164,100.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэргэдийн устгал, ариутгал | 240,000.00 | 240,000.00 | 200,900.00 | 200,900.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,932,600.00 | 1,932,600.00 | 1,261,400.00 | 1,261,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **42,165,200.00** | **16,901,000.00** | **39,828,400.00** | **34,138,600.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 100,000.00 | 1,032,600.00 | 67,000.00 | 67,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 41,563,000.00 | 15,366,200.00 | 39,359,600.00 | 33,670,600.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 502,200.00 | 502,200.00 | 401,800.00 | 401,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1497200.00** | **1497200.00** | **3,365,500.00** | **3,365,500.00** |
| 210604 | Урсгал засвар | 1,497,200.00 | 1,497,200.00 | 3,365,500.00 | 3,365,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **300,000.00** | 0.00 | **167,400.00** | **166,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 300,000.00 | 0.00 | 167,400.00 | 166,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **859,300.00** | **752,300.00** | **287,900.00** | **274,500.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 619,300.00 | 619,300.00 | 287,900.00 | 274,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 240,000.00 | 133,000.00 | | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1710900.00** | **1710900.00** | **1,030,000.00** | **1,030,000.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 210,900.00 | 210,900.00 | 210,900.00 | 210,900.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,500,000.00 | 1,500,000.00 | 819,100.00 | 819,100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **350,000.00** | **10,679,465.00** | **210,900.00** | **3,331,536.06** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 350000.00 | 350000.00 | **210,900.00** | **210,900.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 350,000.00 | 350,000.00 | 210,900.00 | 210,900.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас санхүүжилт** | **-** | **10,329,465.00** | **-** | **3,120,636.06** |
| **213403** | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 10,329,465.00 | - | 3,120,636.06 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **248,603,910.00** | **248,603,910.00** | **255,436,900.00** | **251,037,000.00** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **216,792,210.00** | **216,792,210.00** | **220,636,700.00** | **216,910,500.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 216,792,210.00 | 216,792,210.00 | 220,636,700.00 | 216,910,500.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 31811700.00 | 31,811,700.00 | 34,800,200.00 | 34,126,500.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 31,811,700.00 | 31,811,700.00 | 34,800,200.00 | 34,126,500.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | - | - |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | | | |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1** | **1** | **1** | **1** |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | 1 | 1 |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | | | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **15** | **15** | **15** | **15** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | 1 | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 1 | 1 | 1 | 1 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 9 | 9 | 9 | 9 |
| 620004 | Гэрээт ажилтан | 4 | 4 | 4 | 4 |
| 63 | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | | | | |
| 631 | **СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА** | 137 | 137 | 137 | 137 |
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага | 137 | 137 | 137 | 137 |
| 631002 | Хувийн өмчит СӨБ байгууллага | | | | |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| 11000 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0 |
| 71801 | Сургуулийн өмнөх боловсрол | 675,628.00 |
| 81834 | Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 491,000.00 |
| | Татварын бус орлого | 675,628.00 |
| | Тусламж санхүүжилтийн орлого | 675,628.00 |
| | Төсвөөс санхүүжих | 675,628.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **491,000.00** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 491,000.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **491,000.00** |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | |
| 2104 | Хангамж бараа материалын зардал | 491,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх ахуйн эд зүйлс | 491,000.00 |
| 81835 | Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах | 184,628.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **184,628.00** |
| 26 | Төвлөрүүлэх шилжүүлэг | **184,628.00** |
| 261090 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 184,628.00 |
| 12000 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Өвөрхангай аймгийн Богд сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал

татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Чадварлаг аудит ХХК-ийн аудитор Б.Алтанцэцэг гүйцэтгэж, хяналтыг Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Эрдэнэцэцэг, аудитын менежер Д.Гансүх, газрын дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02-р сарын 17 -ны өдрийн А/04 тоот дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тус байгууллагын зорилго: Сургуулийн өмнөх боловсрол нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд гэсэн зорилготой.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:
Зорилт-1 Бие бялдрын хувьд эрүүл чийрэг өсгөж хөгжүүлэх, ариун цэвэр, эрүүл ахуйн зөв дадал, хэвшилтэй болгох;
Зорилт-2.Хэл яриа, сэтгэхүйн чадвар эзэмшүүлэх, хүрээлэн байгаа орчин, юмс үзэгдлийн талаар анхны мэдэгдэхүүнтэй болгох.
Зорилт-3 Хүүхдийн гоо зүйн мэдрэмжийг хөгжүүлэн дүрслэн зурах, урлан бүтээх, дуулж хөгжимдөх, бүжиглэх чадвар эзэмшихэд туслах;;
Зорилт-4 Хүүхэд өөрийгөө зөв илэрхийлэх, бусдыг хүндэтгэн харилцах, харилцааны хэлбэрээс хүчирхийллийг ялгаж, мэдээлэх чадвартай болох, ардын ёс заншлыг танин мэдэхэд нь туслах.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

БСШУЯамнаас гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажилладаг.

Цэцэрлэгийн бүтцэд дотоод хяналтын орон тооны алба байхгүй. Тус цэцэрлэгийн даргын 2019 оны 12 сарын 20-ны А/18 тоот тушаалаар Дотоод хяналтын багийн бүрэлдэхүүнийг 3 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулж ажиллаж байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өвөрхангай аймгийн Богд сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв

толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

**3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь нийт зардлын үзүүлэлтээр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар 262.0 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 3.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

**3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Тус байгууллагын хувьд тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3.3 сая төгрөгийн камер,зөөврийн компьютер, 1.2 сая төгрөгийн камерын дагалдах хэрэгсэл авсан байна.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангаар Баянховд ХХК-д 218.8 сая төгрөгийн өглөгтэйгээр тайлагнасан боловч тооцоо нийлсэн акт байхгүй баталгаажуулаагүй байна.

Хүнсний материалын хувьд өмнөх оны үзүүлэлтээс 11.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь хавар болохоор үнэ нэмэгдэж ховорддог нойтон мах аарц зэрэг хүнсний материалуудын нөөц бүрдүүлж хадгалсантай холбоотой өссөн.

**3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зориулан 255.4 сая төгрөгийг улс,орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Үүнд: Тусгай зориулалтын шилжүүлгээр үндсэн үйл ажиллагааны зардалд 220.6 сая төгрөг,орон нутгийн төсвөөс 34.8 сая төгрөг тус тус олгохоор төлөвлөсөн. Санхүүжилтийн хэмжээ өмнөх оноос өсөөгүй.

**3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 251.0 сая төгрөгөөр санхүүжигдэн, 251.0 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага тайлант онд 0.6 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг авч сургалтын материал авахад 0.5 сая төгрөгийг зарцуулж 0.1 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

**3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

**3.8 Аудитын гол асуудал**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 3 горим сорил гүйцэтгэсэн.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

**3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

**3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд Нийт 149 мэдээлэл оруулахаас 146 мэдээлэл оруулсан байна Шилэн дансны хуулийн 6.4.4 дэх заалтын дагуу байршуулах мэдээллийг дутуу орхигдуулсан байна.

**3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тайлант хугацаанд мөрдөгдөж буй хууль тогтоомжид томоохон шинэчлэл өөрчлөлт гараагүй байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансны хуульд нийцсэн байна. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтуудад тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 0.5 сая төгрөгийн зөрчилд өгсөн албан шаардлагыг биелүүлсэн байна. Өмнөх аудитын хэрэгжилт 100 хувьтай байна.

**3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгсөн.

**4.1 Залруулсан алдаа**

Байхгүй болно.

**4.2 Төлбөрийн акт**

Байхгүй болно.

**4.3 Албан шаардлага**

Хангамжийн материалын зардлын тайланд 1.6 сая төгрөгийн шатахууныг анхан шатны баримтын бүрдэлгүй, шаардах хуудсаар олгон шууд зардалд тусгасан

**4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. ***Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

Бэлтгэн нийлүүлэгчээс И-баримтгүйгээр нийт 3.9 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээ худалдаж авсан.

*1.2. <u>Өгсөн зөвлөмж:</u>*

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Сангийн сайдын 347 тоот тушаалыг мөрдөж ажиллах

2. ***Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

*2.1 <u>Илрүүлэлт:</u>*

Шилэн дансны мэдээлэлд нийт 149 мэдээлэл оруулахаас 23 мэдээллийг хугацаа хоцруулж мэдээлсэн байна.

*2.2 <u>Өгсөн зөвлөмж:</u>*

*Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж, хуульд заасан хугацаанд мэдээлэх*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Богд сумын 1 цэцэрлэг | 3 | 5.5 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 1.6 | 2 | 3.9 |

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР Б.АЛТАНЦЭЦЭГ

2022 ОНЫ 02 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДӨР